**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 10 өдөр Дугаар А/12 Мөрөн сум

Инженерийн шугам сүлжээний ажлыг
хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2. 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.4, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн "Инженерийн шугам сүлжээ бүхий гэр хороолол төсөл"-ийн хүрээнд хийгдсэн 13 дугаар багийн Дулаан дамжуулах төв №7-ийн барилга угсралт тоноглолын ажил 1,2 дугаар хэлхээний цэвэр ус, дулааны 4,6км шугам сүлжээний ажил, Дулаан дамжуулах төв №8-ийн тоноглолын өргөтгөлийн ажлыг хэсэгчлэн хүлээн авч ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Д.Аюушжав (Аймгийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

С.Анхбаяр (Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)

Г.Даваадорж (Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн ерөнхий инженер)

Ч.Батсүх (Мөрөн сумын Засаг даргын орлогч)

Б.Даваахүү (Мөрөн сумын Байгаль хамгаалагч)

Ц.Зоригт (Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК)

Э.Бат-Оргил (Мөрөн сумын 7 дугаар багийн Засаг дарга)

С.Ариунаа (Мөрөн сумын 13 дугаар багийн Засаг дарга)

Захирамж2024

6712010044

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:
Ж.Ганболд (“Монкузбасс” ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
Н.Бямбадорж (“Энерготех сервис” ХХК-ийн захирал)
Э.Ганхуяг (Энерготех сервис” ХХК-ийн ерөнхий инженер)
Ц.Мэнддо (Энерготех сервис” ХХК-ийн төслийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:
П.Цэнгэнжаргал (Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн инженер)
Д.Сүхээ (Хөвсгөл Ус суваг ХХК-ийн ерөнхий инженер)

Комиссын нарийн бичгийн дарга:
Д.Нямбат (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Инженерийн шугам сүлжээний ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Инженерийн шугам сүлжээний ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ